



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/30

Арвайхээр сум

Газар эзэмших эрх нэгтгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь хэсэг, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 8.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын инженерийн шугам сүлжээ бүхий газарт байрлах 4 нэгж талбарыг эзэмшигчдийн хүсэлтийн дагуу хавсралтад зааснаар газар эзэмших эрхийг нэгтгэсүгэй.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн “Газар эзэмшүүлэх тухай” А/338 дугаар захирамжийн хавсралтын 2,3 дугаар дэсд байгаа Н.Болдбаатартай холбогдох хэсэг, 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Газар эзэмших эрх шинээр олгох тухай” А/541 дүгээр захирамж, 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн “Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай” А/150 дугаар захирамжийн хавсралтын Тэрэмбаян ХХК-тай холбогдох хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0061

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 430 дугаар захирамжийн хавсралт



ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХ НЭГТГЭЖ БУЙ НЭГЖ ТАЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ

Д/д	Газар эзэмшигчийн овог, нэр (Хуулийн этгээдийн нэр)	Эзэмшигчийн регистрийн дугаар	Газрын зориулалт	Газрын хэмжээ (м ²) Газраас	Нэгж талбарын дугаар	Газар эзэмших эрх шилжүүлэн авагчийн овог, нэр (Хуулийн этгээдийн нэр)	Эрх шилжүүлэн эзэмшигчийн регистрийн дугаар	Газрын зориулалт	Газрын хэмжээ (м ²) Газрыг	Газрын байршлын нэр, хаяг	Эзэмших хугацаа
1	Н.Болдбаатар	УС68062011	Амины орон сууц	263	6216034615	Н.Болдбаатар	УС68062011	Амины орон сууц	526	13 дугаар баг, Дөл-1 гудамж, 100 тоот	29 жил
2	Н.Болдбаатар	УС68062011	Амины орон сууц	263	6216034616						
3	Тэрэм баян ХХК	3553736	Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар	5000	6216032025	Тэрэм баян ХХК	3553736	Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар	6000	12 дугаар баг, Үйлдвэрчид-4 гудамж, 405 тоот	8 жил
4	Тэрэм баян ХХК	3553736	Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар	1000	6216034374						